



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 456

Улаанбаатар хот

### Г Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3, Төсвийн тухай хуулийн 10.1.7, 10.1.14, 43.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч наарт даалгасугай:

1.1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дунд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх;

1.2.улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэхээр гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нехцэл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах;

1.3.төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.

2.Энэ тогтоолын 1.1-1.3-т заасан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх болон хөрөнгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулах, санхүүжүүлэхэд шалгуур үзүүлэлт гаргаж, нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.